



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын харьяа Өвөрхангай аймгийн Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 15,000,000.00 (арван таван сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Соната-7 маркийн автомашиныг хавсралтад заасны дагуу ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын Туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Өвөрхангай аймгийн Прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга Т.Ганбат, Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа Д.Одонбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл) т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

123007572
1-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 01 дугаар сарын 11 өдрийн
13 дугаар тогтоолын хавсралт

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООЖ, БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил	Шилжүүлэн хүлээн авах байгууллага
1	Хьюндай Соната-7, улсын дугаар 11-11 ӨВР, арлын дугаар КМНЕС41МВАА029474	2010/2017	15,000,000.00	3,000,000.00	2	Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газар
Нийт дүн			15,000,000.00 (арван таван сая)	3,000,000.00 (гурван сая)		